

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ

Монголын түүхчдийн холбоо, БНСУ-ын Сёгон их сургуулийн Когурё судлалын холбоо хамтран “Түүхийн үнэн ба хятадын түүх бичлэгийн асуудал” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг ШУА-ийн Түүхийн хүрээлэн ивээн тэтгэж 2007 оны 9-р сарын 24-25-ны өдөр Хүрээлэнгүүдийн нэгдсэн I байрны хурлын танхимд зохион байгууллаа.

Тус эрдэм шинжилгээний хурлыг Монголын түүхчдийн холбооны ерөнхийлөгч, академич Ж.Болдбаатар, БНСУ-ын Сёгон их сургуулийн Когурё судлалын холбооны ерөнхийлөгч Хан Гю Чөл нар нээж хэлсэн үгэндээ энэхүү хуралд түүх судлал, археологи түүх бичлэгийн чиглэлээр урдаа барьдаг олон эрдэмтэн мэргэд оролцож буйг цохон тэмдэглэсэн байна.

Монголын талаас академич Ч.Далай “Монголын түүхийг Хятадын түүх бичлэгт гуйвуулж ирсэн байдал”, профессор Д.Цэвээндорж “Mongolanthropus” буюу нэн эртний хүн”, профессор Д.Баяр “Түрэг, Уйгарын үеийн археологийн дурсгалууд”, профессор С.Цолмон “БНХАУ-ын түүх бичлэг дэх Их Монгол улсын судалгаа (монгол хэлээр хэвлэгдсэн зарим бүтээлийн жишээн дээр)”, доктор (Sc.D) Ц.Батбаяр “Монголын шинэ үеийн түүхийн талаарх хятадын түүхчдийн зарим бүтээлийн тухай”, доктор (Ph.D) Д.Эрдэнэбаатар “Хүннү тэрэгний онцлог”, доктор (Ph.D) А.Пунсаг “Юань улсын эдийн засгийн хөгжил ба Хятадын түүх бичлэг”, доктор (Ph.D) Ц.Баттулга “Эртний Солонгос улсын тухай руни бичгийн сурвалжийн нэгэн мэдээ хийгээд сүүлийн жилүүдэд олдсон бичгийн дурсгалуудын тухайд” зэрэг илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.

Уг хуралд манай хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор (Ph.D) Д.Шүрхүү “Хятадын түүх бичлэг дэх Тагна Урианхайн асуудал”, Хятад судлалын тасгийн эрхлэгч доктор (Ph.D) Н.Ариунгуа “Монголын бутралын үе Хятадын түүх бичлэгт”, доктор, профессор Л.Жамсран доктор Ж.Урангоогийн хамт “Монголын цагаагчин гахай жилийн хувьсгалын түүх Хятадын түүх бичлэгт” гэсэн сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.

Харин БНСУ-ын талаас Сө Гил Сү “Түүхийг шинээр авч үзэх гэсэн БНХАУ-ын 30 жил, түүний үйл явц, үр дүн”, Ган Сөнх “Сяньби нар Умард Хятадыг захирсан нь (Умард Вэй улсын жишээн дээр)”, Хан Гю Чөл “Бохайн улс ба нүүдэлчдийн төр улсуудын харилцаа”, Сө Бён Гүг “Хятаны Ляор гүрэн Умард Хятадыг захирсан түүх (Хятан, Хан үндэстний тухай Хятадын хийсвэр үзэл хандлага, шүүмжлэл)”, Ким Ви Хёнх “Зүрчидийн Алтан улс Умард Хятадыг захирсан нь”, Жү Чэ Хёг

“Юань улсын үеийн түшмэдийн давхарга, нийгмийн ялгаварлын асуудлыг шинжлэх нь”, Пак Вон Гил “Өнөөгийн Хятадын түүх бичлэгт Монголын түүхийг гуйвуулсан байдал”, Р.Сэтинкая “Монгол улс дахь Туркийн олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ТИКА/-ын үйл ажиллагаа” гэсэн олон сонирхолтой сэдвүүдээр тус тус илтгэл тавьсаны сацуу бусад залуу судлаач эрдэмтэд хэлэлцүүлэгт оролцон, санал бодлоо чөлөөтэй солилцжээ.

*Мэдээ бэлтгэсэн Д.Золбоо (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан, магистр)*